

НҮҮРС ХУДАЛДАН АВАГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. СОНГОН ШАЛГАРУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Энэхүү сонгон шалгаруулалт нь компаниудаас ирүүлсэн үнийн санал, нийт худалдан авах нүүрсний хэмжээ, урьдчилгаа төлбөрийн хэмжээ, сар бүрийн худалдан авалтын хэмжээ, болон тээврийн асуудлыг бодитоор хамгийн сайн гүйцэтгэх чадварын талаар дүн шинжилгээ хийж, боломжит давуу нөхцөлтэй санал ирүүлсэн худалдан авагч компанийг сонгоход оршино.

- 1.1. Үнийн санал ирүүлэх хүсэлтэй компаниуд нь энэхүү журмын Хавсралт 1, Хавсралт 2-т заасан мэдээллүүдийг холбогдох эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж битүүмжилсэн нэг санал ирүүлнэ.
- 1.2. Компанийн цахим хуудсаар олон нийтэд нээлттэй тавигдсан мэдээллийн хүрээнд гэрээ байгуулах санал ирүүлж буй компаниуд холбогдох баримт бичгийг цахим хуудсанд тавигдсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан ирүүлнэ.
- 1.3. Гэрээ байгуулах санал ирүүлж буй компани нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх чадамжтай хуулийн этгээд байх бөгөөд экспортын борлуулалтад нүүрс импортлогч улсын холбогдох зөвшөөрөл, лицензтэй компани байна.
- 1.4. Гэрээ байгуулах санал ирүүлж буй компани нь “Эрдэнэс-Таван толгой” ХК /ЭТТ/-д аливаа гэрээний дагуу өглөг, өр төлбөргүй компани байх шаардлагатай бөгөөд хэрэв сонгон шалгаруулалтад орох тохиолдолд эхний ээлжинд өр төлбөрөө барагдуулсан байна.
- 1.5. Гэрээний урьдчилгаа төлбөр /30%-иас багагүй/ гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногт ЭТТ-ийн нэрлэсэн банкны дансанд шилжүүлэх боломжтойг нотлох баримт бичгийг зайлшгүй ирүүлнэ.
- 1.6. Заасан хугацаанд санал ирүүлээгүй компанийг сонгон шалгаруулалтад оролцуулахгүй.
- 1.7. ЭТТ нь ижил нөхцөлтэй санал ирүүлсэн компаниудаас Монголын үндэсний аж ахуй нэгж, байгууллагуудыг давуу эрхтэйгээр дэмжин ажиллана. Дотоодын аж ахуйн нэгжийн ирүүлсэн үнийн саналд Монгол улсын хууль тогтоомжийн дагуу заавал төлөгдөх ёстой татвар хураамж /НӨАТ г.м/ багтсан байна.

2. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОГДСОН КОМПАНИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 2.1. Шалгарсан компани нь ЭТТ ХК-аас мэдэгдсэн өдрөөс хойш 48 цагийн дотор ЭТТ ХК-ийн нэрлэсэн банкны дансанд гэрээ байгуулах баталгаа болгож гэрээлэх хэмжээний нүүрсний тонн тутамд 1 ам.доллараар тооцож байршуулна.
- 2.2. ЭТТ ХК нь баталгаа байршуулсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан нүүрс худалдах, худалдан авах гэрээ байгуулна.
- 2.3. Эрх олгогдсон компани гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор урьдчилгаа төлбөр /30%-иас багагүй/ төлөх үүрэг хүлээнэ. Хэрвээ энэ хугацаанд үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээ байгуулах эрхийг цуцална.
- 2.4. Гэрээ цуцлагдсан тохиолдолд гэрээний баталгааг буцаан олгохгүй ба торгууль хэлбэрээр ЭТТ ХК суутган авна.

- 2.5. Эрх олгогдсон компанитай байгуулсан гэрээ цуцлагдсан тохиолдолд хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн эрэмбээр нь ангилж, хамгийн ашигтай санал ирүүлсэн, шаардлага хангасан дараагийн компанитай гэрээ байгуулна.
- 2.6. Нүүрсний тээвэр, ачилтын хуваарь, урьдчилгаа төлбөрийн хувь хэмжээ зэрэг холбогдох гол нөхцөлүүдийг “Нүүрс худалдах, худалдан авах тухай” гэрээгээр зохицуулна.
- 2.7. Шалгарсан компани нь гэрээ хийх эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

ХУДАЛДАН АВАГЧИЙН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

ХУДАЛДАХ НҮҮРСНИЙ МЭДЭЭЛЭЛ:

ЭТТ ХК нь Цанхийн уурхайгаас олборлосон дор дурдсан чанар бүхий 100,000 тонн коксжих нүүрс-ийг тонн тутмыг 71.5 ам.доллар-аас багагүй үнээр борлуулах боломжтой болохыг үүгээр мэдэгдэж байна.

ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ:

Нүүрсний төрөл	Total Moisture (Ar)	Ash (db)	Volatile Matter (daf)	Sulphur content (db)	G index
Коксжих нүүрс	3.72	16.6	28.95	1.1	80

Материал бүрдүүлж буй хуулийн этгээд нь Хавсралт 2-ийг бөглөж доорхи мэдээллийг бүрдүүлж ирүүлсэн байх шаардлагатай. Үүнд:

- Худалдан авах нийт нүүрсний хэмжээ,
- Нүүрсний тонн тутам санал болгож буй үнэ,
- Сар тутам ачилт хийх хэмжээ, хүчин чадал,
- Урьдчилгаа төлбөрийн хэмжээ,
- Тухайн нүүрсийг тээвэрлэх хугацаа,
- Тээврийн хэрэгслийн тоо /нүүрс тээвэрлэх зориулалт бүхий өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгсэлтэй эсэх/,
- Гэрээ байгуулах эрх олгогдсон компанид тавигдах шаардлагын 2.1, 2.4 заалтуудыг хүлээн зөвшөөрсөн албан тоот ирүүлэх ,
- Гэрээ байгуулах эрх олгогдсон компанид тавигдах шаардлагын 2.3 заалтын дагуу урьдчилгаа шилжүүлэх боломжтойг нотлох баримт бичиг ирүүлэх,
- Хүсэлт ирүүлж буй компани нь “Эрдэнэс-Таван толгой” ХК-д аливаа өр, өглөггүй байх,
- Холбогдох тусгай зөвшөөрөл.

МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ЭЦСИЙН ХУГАЦАА: 2017 оны 03-р сарын 17-ны өдрийн 17:00 цагаас өмнө битүүмжилсэн хэлбэрээр ирүүлнэ.

МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ: ЭТТ ХК-ийн байрны 115 тоот.

НҮҮРС ХУДАЛДАН АВАХ САНАЛ ӨГӨХ МАЯГТ

1. ХУДАЛДАН АВАГЧ КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ | 买方信息:

Company name | Компаний нэр | 公司名称: _____

Company address | Компаний хаяг | 公司地址: _____

Phone number | Утасны дугаар | 电话号码: _____

Email address | Цахим хаяг | 电子邮箱: _____

2. ХУДАЛДАН АВАГЧИЙН САНАЛ/煤炭订单

Нүүрсний төрөл | 煤种: Коксжих нүүрс | 动力煤 ☐Үнэ | 价格: USD _____ ☐

Худалдан авах хэмжээ | 煤炭总量:

☐ 100,000

Нүүрс хүлээн авах цэг | 交货点:

☐ Уурхайн ам | 坑口

3. PAYMENT TERM | ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ | 付款方式

Урьдчилгаа төлбөрийн хэмжээ | 预付款数额: _____

(30% буюу түүнээс дээш / not less than 30% / 30%以上)

4. АЧИЛТЫН ХУВААРЬ | 运输计划:

Жил/年	2017												Нийт
Сар/月	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
Хэмжээ /量 (1000 тонн/千 吨)													

Худалдан авагчийн гарын үсэг | 买方签名: _____

Нэр | 签字人姓名: _____

Албан тушаал | 签字人职位: _____

Огноо | 日期: _____

Компанийн
тамга

公司印章